



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар A/31

Модот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт оторлосон отор нүүдэл, мал, амьтны хөдөлгөөнд хяналт тавих, Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч Б.Ганзориг - Засаг даргын орлогч

Нарийн бичиг П.Ганчимэг - Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлгийн улсын байцаагч

Гишүүн Б.Чулуунцэцэг - Нугаар багийн Засаг дарга

Б.Хангай - Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч

Б.Уранчимэг - "Дэрст хайрхан" ХХК-ний малын их эмч

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганзориг) -д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

